

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ (Сонгох даалгавар)****Санамж:**

- 1. Зохиолыг анхааралтай уншиж ойлгоорой.**
- 2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.**
- 3. Сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.**
- 4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)**

**Элсний нүүдэл**

Ононгоор нутагтай нь “Би Онондоо умбаж өссөн” гэнэ. Алтайд нутагтай нь ч гэсэн “Би Алтайнхаа ууланд асаж л өслөө” гэнэ. Би говийн хүн. “Гангийн халуун наранд ёстой л умбаж өслөө дөө” гэнэ. Манай тэнд сүн далай, сүмбэр уул нь үгүй ч усны үнэ, уулын өндрийг бид мэднэ.

Говийн багачуул усаар тоглож өсдөггүй. Усыг чандмань эрдэнэ гэж өсөхөөсөө эхлэн дээдлэн хүндэлдэг болоод ч тэр үү, усны үнийг мэднэ. Ус усны амтыг ч бас танина. Нар хэчнээн л халуун шатах тусам худгийн ус төчнөөн л хүйтэн байна.

Ус хэчнээн хүйтэн байх тусам амт нь тэр алдын л сайхан байдаг. Үүнийг халуун наранд тэмээ усалдаг хүн мэднэ. Гэвч говийнхон явуулын хүнээс ус ундаа үл харамлана. Харин ч өгсөндөө баярлана. Унасан унаагаа ч үл цангаана. Харин ч олон усална. Ус үнэтэй хэр нь сүүн дээр хийхээс цээрлэнэ. Хаа газрынх шиг усыг ус мэт бодож ус шиг арвин гэж ярина.

Морины ам татахгүй гардаг уулаа говийнхон өндөр гэж ярина. Хэрвээ уулыг холын бараа харагдахаар нь л өндөр нам гэдэг юм бол говийн уул шиг өндөр уул гэж хаа ч үгүй. Хонгогийн газрын бараа нүдэнд тов тод тусаж, дөрвөн зүг найман зовхисноо орших юм ил ил. Бударганат хоолой дагасан тэмээн сүрэг зэрэглээнд уул шиг ханаран, хул шарга элсэн гүвээ зээрийн сүрэг шиг шаргалтана.

Ургаа мод, урсгал ус, уулсын өндөр говийнхонд үгүйлэгддэггүйг говь үзээгүй хангайн хүн үл мэднэ. Говь уудам болохоор сонссон хүнд эндхийн хөгжил элсний нүүдэл шиг удаан санагдана. Гэвч элс урсах мөч даган ширхэг ширхгээр чихэнд зөөлөн чимээ гарган урсан нүүнэ. Амьд юм шиг шөнө халуун хонох элсэн дунд байж л гэмээн элсний дуу сонсоно. Говийн амьдрал загийн амь шиг бөх, худгийн ус шиг яндашгүй ээ. (Д.Батбаяр)

1. Эхийн сэдвийг илэрхийлсэн хэлцийг олоорой.
  - A. Унасан газар шороо алт, угаасан ус рашаан
  - B. Ус чандмань эрдэнэ
  - C. Шар нар, бор хоног өнгөрүүлэх
  - D. Шувуу өндөрт нисэвч сүүдэр нь газарт
  - E. Нар баруун хойноос гарах
2. Эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.
  - A. Морины ам татахгүй гардаг уулаа говийнхон өндөр гэж ярина.
  - B. Говийн багачуул усаар тоглож өсдөггүй.
  - C. Говь уудам болохоор эндхийн хөгжил элсний нүүдэл шиг удаан санагдана.
  - D. Говийн амьдрал загийн амь шиг бөх, худгийн ус шиг яндашгүй
  - E. Би Онондоо умбаж өссөн. Би Алтайнхаа ууланд асаж л өслөө.
3. Зохиолч, говийнхны сэтгэлийн сайхныг ямар ямар үгээр илэрхийлсэн бэ?
  - A. сүн далай, сүмбэр уул, гангийн халуун, умбаж өссөн
  - B. усалдаг, ярина, нүүнэ, сонсоно, санагдана
  - C. үл харамлана, баярлана, цээрлэнэ, үл цангаана
  - D. асаж өслөө, умбаж өссөн, бид мэднэ, баярлана
  - E. худгийн ус, өндөр нам, цээрлэнэ, алсын бараа



4. “Говь уудам болохоор сонссон хүнд эндхийн хөгжил элсний нүүдэл шиг удаан санагдана” гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг тодорхойлоорой.
- A. Тойруулал      B. Ихэсгэл      C. Хэтрүүлэл      D. Амьдчилал      E. Адилтгал
5. Эхийн хэсгүүдийг өгүүлбэрээр хураасныг зөв дараалалд оруулаарай.
- A. Ус чандмань эрдэнэ. Би говийн хүн. Хүн, амьтныг ундаалсандаа баярлана. Говийн амьдрал яндашгүй. Говийн уул шиг өндөр уул үгүй.
- B. Ус чандмань эрдэнэ. Хүн, амьтныг ундаалсандаа баярлана. Би говийн хүн. Говийн амьдрал яндашгүй. Говийн уул шиг өндөр уул үгүй.
- C. Говийн амьдрал яндашгүй. Би говийн хүн. Хүн, амьтныг ундаалсандаа баярлана. Говийн уул шиг өндөр уул үгүй. Ус чандмань эрдэнэ.
- D. Би говийн хүн. Говийн уул шиг өндөр уул үгүй. Хүн, амьтныг ундаалсандаа баярлана. Говийн амьдрал яндашгүй. Ус чандмань эрдэнэ.
- E. Би говийн хүн. Ус чандмань эрдэнэ. Хүн, амьтныг ундаалсандаа баярлана. Говийн уул шиг өндөр уул үгүй. Говийн амьдрал яндашгүй.
6. “**Бударганат хоолой** дагасан тэмээн сүрэг зэрэглээнд уул шиг ханаран, **хул шарга** элсэн **гүвээ** зээрийн сүрэг шиг шаргалтана” гэсэн өгүүлбэрийн тодруулсан үгсийг ямар үгээр солин найруулбал оновчтой вэ?
- A. Загт хоолой, шаргал, хонхор
- B. Харганатын хөндий, хонгор шар, жалга
- C. Хайлааст гол, бүгээн, гүвээ
- D. Буттын хөндий, алтан шаргал, толгод
- E. Шавагтын хоолой, ухаа ягаан, товцог
7. “Бударганат хоолой дагасан тэмээн сүрэг зэрэглээнд уул шиг ханаран, хул шарга элсэн гүвээ зээрийн сүрэг шиг шаргалтана” зохиомжийг зөв ялган тодорхойлоорой.
- A. Байгалийн зураглал      B. Ганцаар яриа      C. Харилцан яриа
- D. Баатрын хөрөг      E. Дотоод буюу ганцаар яриа
8. “Гангийн халуун наранд ёстой л умбаж өслөө дөө” өгүүлбэрт сэтгэлийн ямар өнгө аяс илэрсэн бэ?
- A. Харамссан өнгө аяс      B. Хүсэн тэмүүлсэн өнгө аяс
- C. Баталж нотолсон өнгө аяс      D. Сургамжилсан өнгө аяс      E. Шүүмжилсэн өнгө аяс
9. Харшуулах ур маягт тохирох өгүүлбэрийг олоорой.
- A. Эндхийн хөгжил элсний нүүдэл шиг удаан санагдана.
- B. Нар хэчнээн л халуун шатах тусам худгийн ус төчнөөн л хүйтэн байна.
- C. Хоногийн газрын бараа нүдэнд тов тод тусах.
- D. Говийн амьдрал загийн амь шиг бөх, худгийн ус шиг яндашгүй ээ.
- E. Усыг чандмань эрдэнэ гэж өсөхөөсөө эхлэн дээдлэн хүндэлдэг.
10. Дараах өгүүлбэрүүдийн утгын харьцааг тодорхойлоорой.
- “Говийн амьдрал загийн амь шиг бөх, худгийн ус шиг яндашгүй”
- A. Эсрэг утгат      B. Төсөөт утгат      C. Ойролцоо утгат
- D. Зүйлчилсэн утгат      E. Төсөөт ба зүйлчилсэн утгат
11. “.....” гэж ээждээ амласан ёсоор сайн зохиолч болж чадсан юм. цэгийн оронд тохирох хэлцийг олоорой.
- A. Хувьтай хүн хур борооноор      B. Түрүүнд гарсан чихнээс хойно ургасан эвэр урт
- C. Могой гурав тасравч гүрвэлээс урт      D. Хэлсэн үгэндээ эзэн, идсэн хоолондоо сав
- E. Төрөөгүй хүүхдэд төмөр өлгий зэхэх



12. “Бударганат хоолой дагасан тэмээн сүрэг зэрэглээнд уул шиг ханаран, хул шарга элсэн гүвээ зээрийн сүрэг шиг шаргалтана” өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.
- A. Энгийн дэлгэрэнгүй өгүүлбэр      B. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр  
C. Угсарсан нийлмэл өгүүлбэр      D. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр  
E. Холимог нийлмэл өгүүлбэр
13. Хоёр бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийг олоорой.
- A. Гүвээ шаргалтана.  
B. Багачуул усалдаг.  
C. Говийнхон усаа үл харамлана.  
D. Айлын багачуул тоглож өсдөггүй.  
E. Өндөр элсэн гүвээ шаргалтана.
14. “Говийнхон **явуулын хүнээс** ус ундаа үл харамлана” онцолсон үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ?
- A. шууд тусагдахуун      B. харьяаны тодотгол      C. шалтгааны утгат байц  
D. шууд бус тусагдахуун      E. хамжсан тодотгол
15. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
- A. Удахгүй, хотын хүнийг нүүж ирэхэд энэ цэцэг хөлд гишгэгдэх нь лавтай.  
B. Харь овгоос гэрлэх эрхэм ёсыг үүсгэсэн домгийн соёлт баатар бол Зараа цэцэн юм.  
C. Хичээлдээ шамдан суралцдаг ангийн тэргүүлэгч сурагчдын нэг бөгөөд ангийн бусад сурагчдад их тусалдаг.  
D. Би, ээжийгээ энэ хорвоод жаргаахсан гэж боддог хүний үрсийн нэгэн билээ.  
E. Даяар Монголын хуримлах ёсонд буй нэгэн нийтлэг заншил бол хүргэний талаас хүргэх сүй бэлгийн ёс юм.
16. Төрөл биш утгатай үгийг олоорой.
- A. хийцэл      B. хийл      C. хийх      D. хийц      E. хиймэл
17. “Гангийн халуунд умбаж өслөө” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
- A. Ган ган хийх дуу чимээ  
B. Цайвар өнгөтэй хатуу төмөрлөг  
C. Арьс шир дүрж идээлэх тусгай найруулсан зүйл  
D. Шингэн зүйл агуулах том хувин сав  
E. Бороо ус чухаг ховор жил, цаг
18. “Өндөр их хаан сэнтийдээ чи заларч, өрлөг есөн жанжны чинь тоо бүрэн байхад ...” өгүүлбэр найруулгын ямар зэрэгт хамаарах вэ?
- A. Нутгийн аялгуу      B. Дунд      C. Доод      D. Дээд      E. Ерийн
19. Алтайд нутагтай нь ч гэсэн “Би Алтайнхаа ууланд асаж л өслөө” гэнэ. Би говийн хүн. “Гангийн халуун наранд ёстой л умбаж өслөө дөө” өгүүлбэрээс зэрэгцүүлэн онцлох утгатай бүтээврийг олоорой.
- A. л      B. дөө      C. ч      D. д      E. той
20. Зөв бичсэн бүлэг үгсийг олоорой
- A. уншигчын, толбыг, эшлэл, байцаа  
B. тогоочийн, нүүдлэхдээ, гавьяа, санаачлага  
C. мандуулхыг, цамцын, зөвлөгөө, доорхи  
D. доторх, цомхтго, төлөвлө, дохьё  
E. шахснаар, айргийн, уушги, тархи



21. “.....таслал (,) бичнэ” дүрмийг гүйцээж бичээрэй.
- Санаа бүрэн төгссөн хүүрнэсэн өгүүлбэрийн төгсгөлд
  - Ерийн байдлаар захирсан өгүүлбэрийн эцэст
  - Номын нэр, бүлэг, гарчиг, албан газрын хаягийн ард
  - Зэрэгцсэн хэд хэдэн үг, гишүүний хооронд
  - Аливаа хүний хэлсэн үг, бодол санаа зэргийг бичихдээ
22. “гүзээлье” хэмээх үгэнд холбогдох зөв бичгийн дүрмийг олоорой.
- Зөөлний тэмдгийн дараа е орвол зөөлний тэмдэг хэвээр байна.
  - Зөөлний тэмдгээр төгссөн эм үгэнд е эгшигийг шууд залгаж бичнэ.
  - Эм үгэнд е эгшиг өмнөх гийгүүлэгчээсээ саланги дуудагдахаар орвол зөөлний тэмдгээр тусгаарлаж бичнэ.
  - Заримдаг гийгүүлэгчийг зөөлрүүлсэн зөөлний тэмдгийн дараа е орвол зөөлний тэмдэг хэвээр байна.
  - Зөөлний тэмдгийн дараа туслах эгшиг е орвол зөөлний тэмдгийг хэвээр бичнэ.
23. Зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.
- |              |  |
|--------------|--|
| 1. жүжиг     | a) Б.Лхагвасүрэн “Буруу энгэртэй дээл” |
| 2. найраглал | b) Д.Намдаг “Оролмаа”                  |
| 3. тууж      | c) Ц.Дамдинсүрэн “Буурал ээж минь”     |
| 4. шүлэг     | d) Б.Догмид “Мэнд эгч”                 |
| 5. өгүүллэг  | e) Д.Мягмар “Үер”                      |
- A. 1b,2c,3e,4a,5d      B. 1c,2e,3d,4a,5b      C. 1c,2d,3a,4b,5e  
D. 1b,2d,3e,4a,5c      E. 1c,2b,3e,4a,5d
24. Дараах эшлэлүүдээс сарны дүрслэл нь бусдаасаа ялгаатай хэсгийг олоорой.
- Дэрэн дээр саран асгарсан  
Зөөлөн салхитай тэр л үдшээр
  - Цоохор шар саран чавганц  
Цоорхой үүлэн дээлээ хэдрээд
  - Шөнийн чимээгүй гадаа налайн  
Унийн углуургаар саран гэрэлтэнэ
  - Санан санан хүлээсэн  
Сарын сайн өдөр хө
  - Хөгжилтэй тунгалаг сар аа!  
Хөдлөх явах эрх чөлөө чинь хэмжээгүй
25. “Авах гээхийн дөрвөн мөрт” шүлэгт дарааллаар тохирох хэсгийг олоорой.

### Дөрвөн сайн аль буй хэмээвээс

Охь дээдийн номын ёсоор явагчдын.....сайн  
Осол муу явдлыг тэвчигчдийн.....сайн  
Олны тусыг бодогч мэргэдийн.....сайн  
Онц бусдын үйлийг бүтээгчдийн.....сайн

- |                             |                             |
|-----------------------------|-----------------------------|
| A. чадал, санаа, зориг, үйл | B. чадал, зориг, үйл, санаа |
| C. үйл, чадал, санаа, зориг | D. санаа, үйл, зориг, чадал |
| E. үйл, зориг, санаа, чадал |                             |



26. Зөв бичсэн хэсгийг олоорой.

- A.  $\int \sin x \cos x dx = \frac{1}{2} \sin^2 x + C$
- B.  $\int \sin x \cos x dx = -\frac{1}{2} \sin^2 x + C$
- C.  $\int \sin x \cos x dx = \frac{1}{2} \cos^2 x + C$
- D.  $\int \sin x \cos x dx = -\frac{1}{2} \cos^2 x + C$
- E.  $\int \sin x \cos x dx = \frac{1}{2} \sin x \cos x + C$

27. “хичээл” гэсэн үгийг Монгол бичгээр зөв бичсэнийг олоорой.

- A.  $\int \sin x dx$
- B.  $\int \cos x dx$
- C.  $\int \tan x dx$
- D.  $\int \cot x dx$
- E.  $\int \sec x dx$

28. Нэрийн тийн ялгалын нөхцөлийг буруу дагуулсан үгийг олоорой.

- A.  $\int \sin x dx = -\cos x + C$
- B.  $\int \cos x dx = \sin x + C$
- C.  $\int \tan x dx = -\ln |\cos x| + C$
- D.  $\int \cot x dx = \ln |\sin x| + C$
- E.  $\int \sec x dx = \ln |\sec x + \tan x| + C$

29. “ $\int \frac{1}{x} dx = \ln |x| + C$ ” үгст олон тооны дагаврын алийг залгах вэ?

- A.  $\int \frac{1}{x} dx = \ln |x| + C$
- B.  $\int \frac{1}{x} dx = \ln |x| - C$
- C.  $\int \frac{1}{x} dx = -\ln |x| + C$
- D.  $\int \frac{1}{x} dx = -\ln |x| - C$
- E.  $\int \frac{1}{x} dx = \ln |x| + C$

30. “сур” гэсэн үгийг үйлийн хэвийн дагавраар зөв хувилгасныг олоорой.

- A.  $\int \sin x dx = -\cos x + C$
- B.  $\int \cos x dx = \sin x + C$
- C.  $\int \tan x dx = -\ln |\cos x| + C$
- D.  $\int \cot x dx = \ln |\sin x| + C$
- E.  $\int \sec x dx = \ln |\sec x + \tan x| + C$

31. Цэгийн оронд тохирох нөхцөлийг олж зүйр цэцэн үг бүтээгээрэй.

- A.  $\int \sin x dx = -\cos x + C$
- B.  $\int \cos x dx = \sin x + C$
- C.  $\int \tan x dx = -\ln |\cos x| + C$
- D.  $\int \cot x dx = \ln |\sin x| + C$
- E.  $\int \sec x dx = \ln |\sec x + \tan x| + C$



32. Монгол бичгийн эхийг уншаад, зөв хөрвүүлснийг олоорой.

سەر ٤  
سەر ٤  
سەر ٤  
سەر ٤  
سەر ٤

- A. Ах дүү хэнд ч аятай  
Ааль зан нь дөлгөөн
- B. Анх дуу хэнд чи эетэй  
Ааль зан нь дөлгөөн
- C. Ах дүү хэнд чи аятай  
Аль зан нь дөлгөөн
- D. Анх дүү хэнд ч эетэй  
Аль зан нь дөлгөөн
- E. Ах дуу хэнд чи аятай  
Ааль зан ни дөлгөөн

33. “гүүний унага” гэсэн утгыг илэрхийлэх үг аль нь вэ?

- |       |       |       |       |       |
|-------|-------|-------|-------|-------|
| A.    | B.    | C.    | D.    | E.    |
| سەر ٤ | سەر ٤ | سەر ٤ | سەر ٤ | سەر ٤ |

34. Буруу бичсэн үгийг олоорой.

- |       |       |       |       |       |
|-------|-------|-------|-------|-------|
| A.    | B.    | C.    | D.    | E.    |
| سەر ٤ | سەر ٤ | سەر ٤ | سەر ٤ | سەر ٤ |

35. Дараах өгөгдлөөс “гол ус” гэсэн утгыг илтгэх үгийг олоорой.

- |       |       |       |       |       |
|-------|-------|-------|-------|-------|
| A.    | B.    | C.    | D.    | E.    |
| سەر ٤ | سەر ٤ | سەر ٤ | سەر ٤ | سەر ٤ |



**ХОЁРДУГААР ХЭСЭГ (Харгалзуулах даалгавар)****Санамж:**

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Хэлцийг тайлбартай нь зөв харгалзуулаарай.

a. үнэг сүүлээрээ	1. үйл явдлын зүй журмын дэв дарааг зөрчих,
b. яс сайт яван чангарах	2. бачлагдах, хууран мэхлэгдэх
c. нулимсаараа нүүрээ угаах	3. нойр хулжих гэснийг ёгтолсон утга
d. нойрыг нь нохой авах	4. эрчтэй, хүчтэй, итгэлтэй
e. аав болохоосоо өмнө өвөө болох	5. маш их зовох, зүдрэх

2.2 Уран зохиолын төрөл зүйлүүдийг зохиолын хэсэгтэй нь зөв харгалзуулаарай.

- |                  |  |
|------------------|--|
| a. Ерөөл         | 1. Энэ завсар Дагдангийн эхнэрийн таргалсан Цэрмаагийн турсан хоёр яг тэнцэнэ. |
| b. Магтаал       | 2. Буянт их настандаа сайшаагдаж Буйгаараа хамтаар жаргахын билгийг айлтгая    |
| c. Зүйр цэцэн үг | 3. Могойн толгойг дарсан чулууг өдгөө Тайхар чулуу гэдэг болсон гэнэ.          |
| d. Өгүүллэг      | 4. Арван хоёр салаа эвэртэй Буга нь мэхэлзэнхэн урамдаад                       |
| e. Домог         | 5. Идсэн эрүү хувхайрч Идүүлсэн бут ургадаг                                    |

2.3 Зөвийг нь олж сонгоорой.

		1	2	3	4	5
a.	Балархай эгшиг гээгдэх үг	Орхон+ы	тэнхим+ийн	сана+уул	явах+аар	тогоо+ч
b.	Зөөлний тэмдэг үл солигдох үг	морь+л	шуугь+ж	ярь+х	хууль+ийн	захь+на
c.	“-е”-г шууд залгах үг	шүтүүл	үүсгэ	оё	гүйлд	үз
d.	Эр үгэнд “-ыг” бичих үг	тууж	баг	сурагч	бага	багш
e.	“-л” өмнөө эгшигтэй бичигдэх үг	дэл	ногт	чөдөр	олонцог	хазаар

2.4. Дүрс ялган бичих үгсийг тохирох утгатай нь харгалзуулаарай.

a.	1. гуяны хас
b.	2. нэмж хасах
c.	3. эрдэнийн чулуу
d.	4. хасаг тэрэг
e.	5. хонь хаших



**СОНСОХ ДААЛГАВАР**

Гүйцэтгэх хугацаа: 15 минут

[10 оноо]

Санамж:

- “Өвгөн аавын аяга” эхийг мэдэрч, сонсож, ойлгоод асуултад хариулаарай.
- Хариултын олон хувилбараас зөвхөн нэгийг сонгож, хариултын хуудсан дээр /36-40/ зааврын дагуу будаарай.
- Зөв хариулт бүр 2 оноотой

36. Аав хэзээ өвөг аавын аяганд айраг хийсэн бэ?

- A. Цагаан сараас өмнө
- B. Шинийн хоёрны өглөө
- C. Гүү барихаас өмнө
- D. Шинийн нэгний өглөө
- E. Сар шахуугийн өмнө

37. Аяга яагаад хөгжмийн утас шиг жингэнэн дуугарсан бэ?

- A. Өвөг аав тэр дууг хамт урласан учир
- B. Сар шахуу бэлдэж хийсэн учир
- C. Амсрыг нь мөнгөлсөн учир
- D. Савхаар цохисон учир
- E. Амсар дүүрэн айрагтай учир

38. “Өвөг аавын аягатай айргийг би ууна, би ууна” гэсэн өгүүлбэрээр ямар санааг илэрхийлсэн бэ?

- A. Гэр бүлийн аз жаргал
- B. Гэрийн тооныг харах гэсэн
- C. Ач нарын хоорондын маргаан
- D. Амсрыг нь мөнгөлсөн учир
- E. Хөгжим шиг жингэнэх дууг сонсох

39. Эхийн сэдвийг олоорой.

- A. Эв нэгдлийн тухай
- B. Өвөг аавын аяганы тухай
- C. Сөнөтэй айрагны тухай
- D. Цагаан сарын тухай
- E. Аавын захиас, сургамжийн тухай

40. Эхийн гол санааг тодорхойлоорой.

- A. Эвт шаазгай буга барина
- B. Шуудайд хийсэн үхрийн эвэр шиг
- C. Үнэнч сэтгэлд үхэр чулуу уярдаг
- D. Цаг цагаар нэг цадна, цагаан сараар нэг цадна
- E. Аяганы хариу өдөртөө, агтны хариу жилдээ

